

## **“Төв-Соёл” бичил хөтөлбөр.**

### **Нэг. Нийтлэг үндэслэл.**

Манай аймаг газар зүйн байршлын хувьд нийслэлээ тойрон оршиж, төвийн бүсийн тулгуур төв, гадаад дотоодын аялал жуулчлалын бүс нутаг болж хүн ам, эдийн засаг нийгмийн хүрээ өсөн тэлэхийн хирээр суурин соёл иргэншилд нийцсэн үйл ажиллагаа, үйлчилгээ нь доголдож, тухайн орон нутгийн хэмжээнд ахуйн соёлын хоцрогдол бүрэн арилаагүй байгаа нь нийтээр зохицон амьдрах зан үйл харилцааны хандлагад таагүй нөлөө үзүүлж байна.

2007 онд аймгийн ИТХ-аар батлагдсан ”Аймгийн соёлын бодлого”-ыг хэрэгжүүлэхэд орчны болон ахуйн соёлыг дээшлүүлэх ажлыг тодорхой төлөвлөгөө чиглэлтэйгээр орон нутагтаа хэрэгжүүлэх асуудал бидний өмнө тулгарч байна.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго**

Төрт ёсоо хүндэтгэн монгол ардын уламжлалт соёл заншлын дэвшилттэй бүхнийг өвлөн авч, хүн амын ерөнхий болон ахуйн соёлын түвшинг дээшлүүлэх, нийтээр эрхэмлэн дээдлэх соёлыг дэлгэрүүлэхэд оршино.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилтууд**

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- 3.1.** Аймгийн нутаг дэвсгэрт амьдарч буй хүн амын ерөнхий болон ахуйн соёлын түвшинг дээшлүүлэх, ахуй нөхцлийг сайжруулах
- 3.2.** Нүүдлийн уламжлалт соёлоо суурины соёл иргэншилтэй зөв хослуулах, ойлголтыг иргэдийн ухамсар үйл ажиллагаанд хэвшүүлэх
- 3.3.** Үйлдвэрлэл, үйлчилгээнд бизнесийн болон хэрэглээний соёлыг хөгжүүлэхэд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэх.
- 3.4.** ”Төв соёл” бичил хөтөлбөрийг хэрэгжүүлэх таатай орчин бий болгох, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл иргэдийн гүйцэтгэх үүрэг хариуцлагын шинэ тогтолцоо бүрдүүлэх.

### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, хүрэх үр дүн**

#### **1-р Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- 4.1.1.** Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох бүртгэл судалгааг орон нутаг, засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтын дагуу аймаг, сум, баг иргэдийн дунд явуулж, мэдээллийн сан бүрдүүлэх
- 4.1.2.** “Төв соёл” бичил хөтөлбөрийг тус аймгийн нутаг дэвсгэрт сум, баг, айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээнд ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнес, хэрэглээний соёлыг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн системтэй үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх
- 4.1.3.** Сум, баг, айл өрхийн дунд “Тохижилт соёлжилтын загвар сум”, “Тогтвортой хөгжлийг дэмжигч баг”, “Соёлч өрх” шалгаруулах уралдаан зарлаж, шалгарсан сум, багийн үйл ажиллагаа, туршлага санаачилгыг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх
- 4.1.4.** Айл өрх бүр удам угсаагаа мэдэж овог сэргээх, угийн бичиг хөтлөх ажлыг хэвшүүлэх
- 4.1.5** Байгууллага, аж ахуйн нэгжүүд ажиллагчдын ерөнхий соёлын түвшинг дээшлүүлэх, үйлчилгээний болон үйлчлүүлэгчдийн соёлыг дээшлүүлэх аяныг жил бүр зохион байгуулах

**4.1.6.** Сумдад нийтийн ахуйн үйлчилгээг сэргээн ажиллуулж, ялангуяа халуун усны үйлчилгээг тогтмолжуулах, багт хэвлэл, шуудан, интернет-мэдээллийн өргөн үйлчилгээг хүргэх, үйлчилгээний чанарыг сайжруулах

**4.1.7.** Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, айл өрхийн ариун цэвэр, эрүүл ахуй, орчны тохижилтын талаарх стандартыг гаргаж мөрдүүлэх

**4.1.8.** Төрийн үйлчилгээний байгууллагуудын “Нэг цэгийн үйлчилгээг”- бий болгон иргэдэд хүргэх үйлчилгээг нээлттэй ил тод болгох, төрийн ажилтан албан хаагчдын харилцааны соёл, ёс зүйг сахих ажлуудыг зохион байгуулах

**4.1.9.** Хөдөөгийн айл өрх, багийн төвийг, нар салхины эрчим хүчээр хангаж, соёл урлаг, холбоо, мэдээллийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

**4.1.10.** Орчин үеийн машин техник хэрэгсэл менжментийг нэвтрүүлж, гудамж талбайд хоггүй болгох

#### **Хүрэх үр дүн:**

1. Ахуйн болон нийтийн үйлчилгээний харилцааны соёлыг дээшлүүлэх үйл ажиллагаанд иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо сайжирч, нийтийн соёлын талаарх хамтын ажиллагааны шинэ тогтолцоо төлөвшинө.

2. Нийтийн болон орчны соёлжилтийн талаар загвар сум, баг, өрхүүд бий болж, соёлжилтийн аяны хүрээ өргөжнө.

#### **2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

**4.2.1.** Соёлын олон талт утгыг таниулах. хүмүүсийн зан үйл, хүний ухамсарт оюун ухаан, үйл ажиллагаанд хэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх

**4.2.2.** Хүний бүтээлч үйл ажиллагааг идэвхижүүлэхэд соёлын гүйцэтгэхүүргийн болон ач холбогдлын талаар иргэд аж ахуйн нэгж албан байгууллагуудын онцлогт тохирсон сургалт, сурталчилгааг зохион байгуулж гарын авлага, товхимол гаргах, мэдээллийн цагийг нэмэгдүүлэх

**4.2.3.** Хүүхэд, залуучуудыг нийгмийн харилцаанд соёлтой оролцох, шинэ иргэн төлөвшүүлэх хөдөлгөөн, аян зарлаж явуулах

#### **Хүрэх үр дүн:**

Нийтийн соёлын талаарх сургалт, сурталчилгааны ажлын үр нөлөө дээшилнэ.

#### **3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

**4.3.1.** Төв суурин газрын барилга, ногоон байгууламж, гудамж талбайн гэрэлтүүлэг, чимэглэл, реклам сурталчилгааг хот төлөвлөлттэй уялдуулан сайжруулан хангуулах

**4.3.2.** Төв суурин газарт гэр хороолол, орон сууцны хорооллын байршлыг оновчтой тогтоож, гэр хорооллыг гэрэлтүүлэгтэй болгох, гудамж, хашааг цэвэр байлгах, хаяг дугаарыг тодорхой болгон орчны болон нийтийн соёлын хэм хэмжээг мөрдүүлэх.

**4.3.3.** Аймаг, сумын төв суурины төвийг цэцэрлэгжүүлэх хөдөлгөөнийг өрнүүлж, мод тарих, зүлэгжүүлэх ажилд байгууллага, иргэн бүрийг татан оролцуулах,

**4.3.4.** Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг төрөлжүүлэн боловсруулах цэгийг сум бүрт байгуулж ажиллуулах

**4.3.5.** Төв суурин газрын нийтийн тээврийн үйлчилгээ, бизнесийн объектуудын харилцаа, үйлчилгээний болон замын хөдөлгөөнд оролцох соёлыг дээшлүүлэх.

**4.3.6.** Нийтийн үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлэх, сургах үйл ажиллагааг зохион байгуулах

#### **Хүрэх үр дүн:**

Төв суурины гудамж талбайн тохижилт, байгууллага, аж ахуйн нэгжийн орчны засал чимэглэл, өнгө үзэмжийг сайжирна.

#### **4-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэдийн оролцоо, хүлээх үүргийг дараах чиглэлээр тогтооно:

Үүнд:

##### **4.4.1.Аймгийн Засаг даргын Тамгын газар:**

- орчны болон харилцааны соёлыг ахуй нөхцөлтэй нь уялдаатайгаар судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх,хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг нийгмийн харилцаанд хэвшүүлэх

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэл, төсөвт тусгах

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, идэвх санаачлагыг дэмжих

-Хөтөлбөрийн хэрэгжилтэнд явц, үр дүнд хяналт тавж шаардлагатай арга хэмжээг авах.

##### **4.4.2.Аймгийн Боловсрол соёлын газар:**

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх арга замыг тодорхой, хамрагдах хүрээг нэмэгдүүлж, судалгаа сурталчилгааны үйл ажиллагааг тогтворжуулах

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд шаардагдах зардал,хөрөнгийг жил бүр төсөвт тусган батлуулах

-Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн аймгийн ИТХ, ЗДТГ болон иргэд олон нийтэд жил бүр тайлагнана.

##### **4.4.3.Сумын ЗДТГ:**

-Хөтөлбөрийг сумын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, орон нутгийн хэмжээнд хэрхэн хэрэгжиж буйд хяналт тавих

-Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж зохистойгоор зарцуулах

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сурталчилгааны аян, сургалт зохион байгуулах

-Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг аймгийн ЗДТГ, БСГазарт хагас бүтэн жилээр тайлагнана.

##### **4.4.4.Аймгийн Мэдээлэл технологийн төв, орон нутгийн мэдээллийн нэгж:**

-Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагууд нийтлэл нэвтрүүлгийн бодлого, хөтөлбөртөө нийтийн соёлтой холбогдох нэвтрүүлэг,сурталчилгааны тоог нэмэгдүүлэн чанарыг дээшлүүлж арга хэлбэрийг боловсронгуй болгоно.

-Зуунмод студи, сумдын телевизүүд нийтийн соёлын талаар тогтмол явуулдаг нэвтрүүлгийн цагтай болох

-Төв таймс сонинд “Төв соёл” бичил хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлыг сурталчлах байнгын булан гаргах

##### **4.4.5.Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж:**

-Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж,иргэдийн дунд нийтийн соёлын чиглэлээр болзолт уралдаан зарлан дүгнэх, тэдний санал санаачлагыг дэмжин ажиллах

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцох, дэмжлэг туслалцаа үзүүлэх, уламжлалт зан үйлийг нийгмийн тодорхой давхаргын хүрээнд хэвшүүлэх үйл ажиллагааг гэрээлэн авч хэвшүүлэх

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, ажлын үр дүнгээ аймаг, сумын төр захиргааны байгууллагад мэдээлж байна.

#### **4.4.6.Гэр бүл, иргэдийн оролцоо:**

-Үр хүүхэд, гэр бүлийнхээ гишүүдийн ахуйн болон харилцааны соёлд суралцуулах, соёлтой харилцааны орчин бүрдүүлэх

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар сум, баг, төрийн болон ТББ-уудаас зохиож байгаа ажилд идэвхитэй оролцох

#### **Хүрэх үр дүн:**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч субъектүүдийн үйл ажиллагаа тогтомолжиж, дэвшүүлсэн зорилтууд хэрэгжих боломж, нөхцөл хангагдна.

#### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт:**

Хөтөлбөрийг 2008-2011 оны хугацаанд хэрэгжүүлнэ. “Төв соёл” бичил хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв
- Аймгийн соёл урлагийн хөгжлийг дэмжих сан
- Гадаад дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив,тусламжийн хөрөнгө
- Бусад эх үүсвэр

#### **Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ:**

**6.1** Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулалт,мэдээллээр хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих үүрэг бүхий зөвлөлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулна.

**6.2** Сумдад хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах, хяналт тавих үүрэгтэй ажлын хэсэг ажиллана. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүний ажлын чиг үүргийг сумын Засаг дарга батална. Багт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүргийг багийн Засаг дарга гүйцэтгэнэ.

**6.3** Сум багт мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж сургалт сурталчилга явуулах үүргийг сумын соёлын төв хариуцана.

**6.4** Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтод нийцүүлэн ажлаа жилээр төлөвлөн хэрэгжүүлж, жил бүрийн 12 дугаар сард аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж байна. Сумдын Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтэс агентлагууд хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жилээр гаргаж НБЗХэлтэст ирүүлнэ.

#### **Долоо.Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:**

**7.1.** “Төв соёл” бичил хөтөлбөр, түүний хүрээнд хийгдэж буй ажлууд аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүрч тэдний гүйцэтгэх үүрэг хариуцлагын тогтолцоо бүрдсэн байна.

**7.2.** Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх судалгаа, сургалт сурталчилгааны ажил тогтомолжиж үр дүн нь тодорхой болсон байна.

7.3. Аймгийн иргэдийн ахуйн соёлын төвшин дээшилж, ахуйн нөхцөл сайжирсан байна.

7.4. Аймгийн аж ахуйн, нэгж, байгууллагуудын тохижилт, үйлчилгээ сайжирч хүндээ чиглэсэн, хөнгөн шуурхай, соёлтой болсон байна

**Нийгмийн бодлого зохицуулалтын хэлтэс.**